



## **ИНД - 101**

Иргэний Нисэхийн Дүрэм

**Жиро-глайдер ба парасэйл, хүнгүй агаарын хөлөг  
(бөмбөлөг, дроныг багтаасан), цаасан шувуу, пуужингийн  
үйл ажиллагааны дүрэм**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-101 нь дараах ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааны шаардлагыг тогтооно:

- хүнгүй агаарын хөлөг, үүнд:
  - аргамжаат бөмбөлөг;
  - чөлөөт бөмбөлөг;
  - зайнаас удирддаг агаарын хөлөг;
  - утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар;
  - чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар;
- Цаасан шувуу;
- Пуужин;
- Жиро-глайдер;
- Парасэйл.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-101-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-101, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

**Өөрчлөлтийн түүх****Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт

2002 оны 12 сарын 20

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 2

2015 оны 05 сарын 20

Нэмэлт, өөрчлөлт 3 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-101-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 101 А.8-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>6</b>
101.1. Хамрах хүрээ.....	6
101.3. Тодорхойлолт.....	6
101.5. Бүртгэл .....	8
101.7. Хязгаарлалттай, цэргийн үйл ажиллагааны болон аюултай бүс.....	8
101.9. Нам өндрийн нислэгийн зоон.....	8
101.11. Хяналттай агаарын зай .....	8
101.12. Агаарын зайн мэдлэг .....	9
101.13. Аюул болон эрсдэлийг багасгах .....	9
101.15. Эд зүйлс хаях.....	9
<b>В Бүлэг - Аргамжаат бөмбөлөг болон цаасан шувуу</b> .....	<b>10</b>
101.51. Хамрах хүрээ.....	10
101.53. Аэродромын бүс.....	10
101.55. Аэродромын хил хязгаар.....	10
101.57. Агаарын зай.....	10
101.59. Шөнийн үйл ажиллагаа.....	11
101.61. Бөмбөлөг аргамжих уяаны тэмдэглэгээ .....	11
101.63. Бөмбөлгийн хийг хурдан гаргах төхөөрөмж .....	11
101.65. Бөмбөлөг алдуурах.....	11
<b>С Бүлэг - Чөлөөт бөмбөлөг</b> .....	<b>12</b>
101.101. Хамрах хүрээ.....	12
101.103. Цаг уурын хязгаарлалт .....	12
101.105. Үйл ажиллагааны хязгаарлалт.....	12
101.107. Төхөөрөмж.....	12
101.109. Таслан зогсоох .....	13
101.111. Шөнийн үйл ажиллагаа.....	13
101.113. Сүүлэн антен.....	13
101.115. Дүүжин хэрэгсэл.....	13
101.117. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл .....	14
101.119. Хөөргөлтийн мэдээлэл .....	14
101.121. Цуцлалтын мэдээлэл.....	15
101.123. Бөмбөлгийн байршлыг илтгэх.....	15
101.125. Өндөр алдалтын өмнөх байршлыг илтгэх.....	15
101.127. Үйл ажиллагааны гүйцэтгэл .....	16
<b>Д Бүлэг - Пуужин</b> .....	<b>16</b>
101.151. Хамрах хүрээ.....	16
101.153. Том загвар пуужин .....	16
101.155. Аэродром.....	16
101.157. Цаг уурын хязгаарлалт .....	16
101.159. Шөнийн үйл ажиллагаа.....	17
101.161. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл .....	17

<b>Е Бүлэг - Зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар .....</b>	<b>17</b>
101.201. Хамрах хүрээ.....	17
101.202. Зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага .....	17
101.203. Утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар .....	18
101.205. Аэродром.....	18
101.207. Агаарын зай.....	19
101.209. Шууд харж удирдах үйл ажиллагаа .....	20
101.211. Шөнийн үйл ажиллагаа.....	21
101.213. Хөдөлгөөний давуу эрх.....	21
101.215. Агаарын хөлгийн жингийн хязгаар .....	21
<b>Ф Бүлэг - Жиро-глайдер, Парасэйл .....</b>	<b>22</b>
101.251. Хамрах хүрээ.....	22
101.253. Аэродром.....	22
101.255. Агаарын зай.....	22
101.257. Цаг уурын хязгаарлалт .....	23
101.259. Шөнийн үйл ажиллагаа.....	23
101.261. Нислэгт тэнцэх чадвар .....	23
101.263. Аюулгүй байдлын төхөөрөмж .....	23
101.265. Нислэгийн өмнөх зааварчилгаа .....	23
101.267. Онцгой нөхцөлийн үед чирэх холбоосыг салгах.....	24
101.269. Үйл ажиллагааны журам .....	24
101.271. Салхины хурд.....	24
101.273. Зорчигчийн насны хязгаарлалт.....	24

## А Бүлэг - Ерөнхий зүйл

### 101.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь ИНД-102.21-ийг харгалзан, дараах төхөөрөмжийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) аргамжаат бөмбөлөг болон цаасан шувуу;
- (2) чөлөөт бөмбөлөг;
- (3) пуужин;
- (4) зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар;
- (5) жиро-глайдер болон парасэйл.

### 101.3. Тодорхойлолт

Энэ Дүрэмд:

**Аргамжаат бөмбөлөг** гэж максимум диаметр нь 1.5 метрээс их, эсхүл 3м<sup>3</sup>-ээс дээш хийн багтаамжтай, газрын гадаргуугаас, эсхүл газрын гадаргуу дээрх байгууламжаас аргамжсан нисгэгчгүй бөмбөлгийг;

**Аэродром** гэж Монгол Улсын хүчинтэй AIP-д зарлагдсан аэродромыг;

**Дунд чөлөөт бөмбөлөг** гэж дараах бөмбөлгийг:

- (1) дараах нийлбэр жин бүхий хоёр, эсхүл түүнээс дээш төлбөрт ачаа тээвэрлэх:
  - (i) 4кг-аас их;
  - (ii) 6кг-аас бага;
- (2) хүнд чөлөөт бөмбөлгийн тодорхойлолтод заагдсан аливаа шалгуурыг хангаагүй;

**Жиро-глайдер** гэж, хүн, эсхүл хүмүүсийг тээх чадвартай, газар, эсхүл усан гадаргуугаас чирдэг, агаарын урсгалын харилцан үйлчлэлээр ихэвчлэн босоо тэнхлэгтэй нэг, эсхүл хэд хэдэн ротор чөлөөтэй эргэн агаарт хөөрдөг, хөтлөгч хүчний төхөөрөмжгүй агаараас хүнд агаарын хөлгийг;

**Загвар пуужингийн аюулгүй байдлын дүрэм** гэж Монгол Улсын Нисэх Загварын Спортын Нийгэмлэгээс гаргасан дүрмийг;

**Зайнаас удирддаг агаарын хөлөг** гэж алсын удирдлагаар нисгэдэг хүнгүй агаарын хөлгийг, үүнд:

- (1) радио удирдлагатай агаарын хөлгийн загвар болон дрон багтана; гэхдээ
- (2) утсан удирдлагатай, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар багтахгүй;

**Парасэйл** гэж ихэвчлэн задгай, дугуй шүхэр хэлбэртэй, моторт завь, эсхүл тээврийн хэрэгслийн араас аргамжин чирж, хүн, эсхүл хүмүүсийг тээн нислэгт хөөргөдөг агаараас хүнд нисдэг төхөөрөмжийг;

**Пуужин** гэж өөрийн тийрэлтэт хүч үүсгэхэд шаардлагатай бүх бодисыг өөртөө агуулсан системээр түлхэгдэж хөөрдөг, дараахаас бусад нисгэгчгүй тээврийн хэрэгслийг:

- (1) тэнгэрийн галын наадам (салют); эсхүл
- (2) нийт 20 Ньютон-секундээс ихгүй тийрэлтийн хүчтэй, A-D хэмжээтэй пуужингийн загварын мотороор түлхэгдэж хөөрдөг пуужин;

**Том загвар пуужин** гэж дараах пуужинг:

- (1) 25гр-аас их, гэхдээ 125гр-аас ихгүй шатагч түлш хэрэглэдэг;
- (2) 20 Ньютон-секундээс их, гэхдээ 320 Ньютон-секундээс ихгүй нийт түлхэлтийн хүч үүсгэдэг;
- (3) удаан шаталттай түлш хэрэглэдэг;
- (4) цаас, мод, резин, хуванцар зэрэг хөнгөн жинтэй материалаар хийгдсэн;
- (5) металлаар хийгдсэн конус хошуу, тэнцвэржүүлэгч, эсхүл металл их биегүй;
- (6) нийт жин нь шатагч түлшний хамт 453гр-аас их, гэхдээ 1.5кг-аас ихгүй;

**Утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар** гэж тухайн агаарын хөлгийг нисгэж байгаа этгээд нэг, эсхүл хэд хэдэн утсаар удирддаг, нэг төвтэй тойргоор хязгаарлагдан нисдэг агаарын хөлгийн загварыг;

**Халхлагдсан үйл ажиллагаа** гэж байгалийн, эсхүл хүний бүтээсэн байгууламжийн оройгоос доош, 100м дотор хийгдэх агаарын хөлгийн үйл ажиллагааг;

**Хүнд чөлөөт бөмбөлөг** гэж дараах чөлөөт бөмбөлгийг:

- (1) төлбөрт ачаа тээвэрлэдэг:
  - (i) нийлбэр жин нь 6кг, эсхүл түүнээс дээш жинтэй; эсхүл
  - (ii) төлбөрт ачааны багц нь 3кг, эсхүл түүнээс дээш жинтэй; эсхүл
  - (iii) төлбөрт ачааны багц нь 2кг, эсхүл түүнээс дээш, 13гр/см<sup>2</sup>-аас их талбайн нягтралтай;
- (2) төлбөрт ачааг олс, эсхүл бусад хэрэгсэл ашиглан дүүжилдэг, бөмбөлөгт дүүжилсэн тухайн төлбөрт ачааг салгахад 230 Ньютон, эсхүл түүнээс их үйлчлэх хүч шаарддаг;

**Цаасан шувуу** гэж хөдөлгөөнгүй цэгт бэхэлсэн, эсхүл гараар барьж салхины хүчээр хөөрдөг, хүчний үүсгүүргүй, нисгэгчгүй агаараас хүнд нисдэг төхөөрөмжийг;

**Чөлөөт бөмбөлөг** гэж 1.5м<sup>3</sup>-ээс дээш хийн багтаамжтай, чөлөөт нислэгт хүчний үүсгүүргүй, нисгэгчгүй аэростатыг;

**Чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар** гэж хөөргөснөөс хойш удирдах боломжгүй нислэгийн замтай, далавчны максимум ачаалал нь 62гр/дм<sup>2</sup>-аас (20oz/ft<sup>2</sup>) ихгүй агаарын хөлгийн загварыг.

**101.5. Бүртгэл**

ИНД-47-гийн шаардлага нь хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, пуужин, парасэйл болон жиро-глайдерт хамаарахгүй.

**101.7. Хязгаарлалттай, цэргийн үйл ажиллагааны болон аюултай бүс**

(a) Тухайн этгээд нь хязгаарлалттай бүсийн үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, түүнийг ИНД-71-ийн дагуу тогтоосон хязгаарлалттай бүсэд хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

(b) Тухайн этгээд нь цэргийн үйл ажиллагааны бүсийн үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, түүнийг ИНД-71-ийн дагуу тогтоосон цэргийн үйл ажиллагааны бүсэд хүнгүй агаарын хөлөг, цаасан шувуу, жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

(c) Тухайн этгээд нь аюултай бүстэй холбоотой тухайн үйл ажиллагаа нь жиро-глайдер, эсхүл парасэйлийн аюулгүй байдалд нөлөөлөхгүй болохыг тогтоосноос бусад тохиолдолд, түүнийг ИНД-71-ийн дагуу тогтоосон аюултай бүсэд жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

**101.9. Нам өндрийн нислэгийн зоон**

ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зоонд, тухайн этгээдийг дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жиро-глайдер;
- (5) парасэйл.

**101.11. Хяналттай агаарын зай**

Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд, тухайн агаарын зайг хариуцсан НХУ-ын нэгжээс урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр, аливаа этгээдийг дараах төхөөрөмжөөр хяналттай агаарын зайд үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жиро-глайдер;
- (5) парасэйл.



**101.12. Агаарын зайн мэдлэг**

(a) Энэ дүрэм нь дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд хамаарна:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жиро-глайдер;
- (5) парасэйл.

(b) Энэ дүрэм хамааралтай этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) нислэг бүрийн өмнө тухайн этгээдийг ИНД-71-ийн дагуу тогтоосон тухайн агаарын зайн ангилал болон үйл ажиллагаа явуулахаар зорьсон бүсийн холбогдох агаарын зайн хязгаарлалтын талаар мэдэж байгааг бататгах; эсхүл
- (2) тухайн үйл ажиллагааг ИНД-71-ийн дагуу тогтоосон тухайн агаарын зайн ангилал болон үйл ажиллагаа явуулахаар зорьсон бүсийн холбогдох агаарын зайн хязгаарлалтын талаар мэдлэгтэй этгээдийн шууд хяналтад гүйцэтгэх.

**101.13. Аюул болон эрсдэлийг багасгах**

Дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь хүн, өмч хөрөнгө болон бусад агаарын хөлөгт учирч болзошгүй аюулыг багасгах боломжит бүх арга хэмжээг авах үүрэгтэй:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жиро-глайдер;
- (5) парасэйл.

**101.15. Эд зүйлс хаях**

Дараах төхөөрөмжөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд, хэрэв тухайн үйлдэл нь хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулахаар бол, нислэгийн үед аливаа зүйлийг хаяхыг зөвшөөрөхийг хориглоно:

- (1) хүнгүй агаарын хөлөг;
- (2) цаасан шувуу;
- (3) пуужин;
- (4) жиро-глайдер;
- (5) парасэйл.

## **В Бүлэг - Аргамжаат бөмбөлөг болон цаасан шувуу**

### **101.51. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь, аргамжаат бөмбөлөг болон цаасан шувууны үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

### **101.53. Аэродромын бүс**

Аливаа этгээд нь аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар дараах үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) аэродромын ашиглагдаж байгаа агаарын хөлгийн хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл
- (2) аливаа хөөрч буух зурвас, эсхүл хөөрч буух зурвасын үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр.

### **101.55. Аэродромын хил хязгаар**

Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааны хувьд, дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь аэродромын хил хязгаараас 4км дотор аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь газрын түвшнээс дээш (AGL) 120м-ээс (400ft) дээш хэтрэхгүй бол;
- (2) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120м-ээс (400ft) багагүй зайд хэвээр тогтож байгаа бол;
- (3) тухайн алсын барааны харагдац 4км-ээс багагүй бол;
- (4) хэрэв тухайн аэродром нь хяналттай аэродром бол, НХУ-аас зөвшөөрөл авсан бол;
- (5) хэрэв тухайн аэродром нь хяналтгүй аэродром бол, тухайн үйл ажиллагааг аэродромын оператортой байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх бол.

### **101.57. Агаарын зай**

(a) Халхлагдсан үйл ажиллагаанаас бусад тохиолдолд, аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт үйл ажиллагаа явуулж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) ИНД-71-ийн дагуу, тухайн зорилгоор тогтоосон аюултай бүсэд үйл ажиллагаа эрхлэх; эсхүл
- (2) энэ зүйлийн (b)-д заасан хязгаарлалтын дагуу үйл ажиллагаа эрхлэх.

(b) Аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар аюултай бүсийн гадна, газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт үйл ажиллагаа явуулж байгаа этгээд нь дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь аливаа аэродромын хил хязгаараас 4км-ээс хол зайд байнга байгааг;
- (2) тухайн бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь G ангиллын агаарын зайд байнга байгааг;
- (3) тухайн цаасан шувууны жин 15кг-аас хэтрээгүйг;
- (4) бөмбөлөг, эсхүл цаасан шувуу нь үүлнээс доош 120м-ээс (400ft) доошгүй босоо зайд байнга байгааг;
- (5) тухайн алсын барааны харагдац 4км-ээс багагүй байгааг;
- (6) тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө NOTAM-д дараах мэдээллийг өгснийг:
  - (i) тэдний нэр, хаяг, утасны дугаар;
  - (ii) тухайн үйл ажиллагаа эрхлэх өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;
  - (iii) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувууны хэмжээ, зонхилох өнгийг багтаасан товч тайлбар;
  - (iv) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувууны жин;
  - (v) тухайн аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар үйл ажиллагаа эрхлэх өндөр.

#### **101.59. Шөнийн үйл ажиллагаа**

Аливаа этгээд нь аргамжаат бөмбөлөг, эсхүл цаасан шувуугаар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

#### **101.61. Бөмбөлөг аргамжих уяаны тэмдэглэгээ**

Аливаа этгээд нь газрын түвшнээс дээш 45м-ээс (150ft) ихгүй өндрөөс эхлэн бөмбөлгийн аргамжааны дагуу 15м тутамд, 1.8км-ээс (1nm) хол зайнаас харагдахуйц өнгөт тууз, эсхүл дарцаг бэхэлснээс бусад тохиолдолд, өдрөөр аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

#### **101.63. Бөмбөлгийн хийг хурдан гаргах төхөөрөмж**

Аливаа этгээд нь, хэрэв бөмбөлөг аргамжаанаас алдуурвал хийг автоматаар, хурдан гаргах төхөөрөмжөөр тоноглогдсоноос бусад тохиолдолд, аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй.

#### **101.65. Бөмбөлөг алдуурах**

Бөмбөлөг аргамжаанаас алдуурахад түүний хийг гаргах хэрэгсэл зохих ёсоор ажиллаагүй бол, тухайн аргамжаат бөмбөлгөөр үйл ажиллагаа явуулж байгаа этгээд нь ойролцоох НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг яаралтай мэдээлнэ:

- (1) тухайн бөмбөлгийн анхны байрлал;
- (2) тухайн бөмбөлөг алдуурсан цаг;

- (3) тухайн бөмбөлгийн тооцоолсон нислэгийн зам.

## **С Бүлэг - Чөлөөт бөмбөлөг**

### **101.101. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь чөлөөт бөмбөлгийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

### **101.103. Цаг уурын хязгаарлалт**

Зохих НХҮ-ээс зөвшөөрснөөс бусад тохиолдолд, аливаа этгээд нь 18 000м-ийн (60 000ft) даралтын түвшинд, эсхүл түүнээс доош аливаа түвшинг нэвтлэн хүнд чөлөөт бөмбөлгөөр дараах тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) үүл, эсхүл тодорхой бус үзэгдэл 4 - 8 октантаас дээш хамарсан бол;
- (2) тухайн алсын барааны харагдац 8км-ээс бага бол;
- (3) бусад улсын нутаг дэвсгэрийн агаарын зайд зөвшөөрөлгүй нэвтэрч болзошгүй бол.

### **101.105. Үйл ажиллагааны хязгаарлалт**

Аливаа этгээд нь, хүнд, эсхүл дунд чөлөөт бөмбөлөг дараах байдлаар нисэхээр бол, түүнийг суллан тавихгүй:

- (1) хот, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр 300м-ээс (1000ft) доош өндөрт; эсхүл
- (2) олон хүмүүс цугларсан задгай талбайн дээгүүр.

### **101.107. Төхөөрөмж**

Аливаа этгээд нь дараахаас бусад тохиолдолд, хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) дараах байдлаар тоноглогдсон бол:
  - (i) нэгнээсээ үл хамааран автоматаар, эсхүл телеметрийн удирдлагаар ажилладаг, төлбөрт ачааг нислэгт салгах хоёроос доошгүй төхөөрөмж, эсхүл системээр;
  - (ii) газарт байрласан SSR төхөөрөмж ашигладаг бүсэд нислэгийн түвшинг илтгэх чадвартай, тогтоосон кодоор тасралтгүй ажилладаг, эсхүл бөмбөлгийн нислэгийн хяналтын төвөөс шаардлагатай тохиолдолд, асаах боломжтой хоёрдогч ажиглалтын радар-транспонпероор;
- (2) тэг даралттай полиэтилен бөмбөлгийн хувьд, нэгнээсээ үл хамааран ажилладаг, хоёроос доошгүй арга, систем, хэрэгсэл, эсхүл тэдгээрийг нэгтгэсэн, нислэгийг таслан зогсоох төхөөрөмжтэй бол;
- (3) бөмбөлгийн бүрхүүл нь дараах байдлаар тоноглогдсон бол:

- (i) радарын дохиог ойлгогч нэгээс доошгүй хэрэгслээр; эсхүл
- (ii) 2 700 - 2 900МГц давтамжийн хүрээнд ажиллаж байгаа газрын радарт эхо үүсгэх радар ойлгогч материалаар.

#### **101.109. Таслан зогсоох**

Хүнд бөмбөлгөөр үйл ажиллагаа явуулж байгаа аливаа этгээд нь, дараах нөхцөлд тухайн нислэгийг таслан зогсоохоор 101.107(1)(i) болон (2)-т шаардсан зориулалтын таслан зогсоох хэрэгслийг ажиллуулна:

- (1) цаг уурын нөхцөл 101.103-т заасан нөхцөлөөс муудсан бол; эсхүл
- (2) цаашдын үйл ажиллагаа нь бусад нислэгийн хөдөлгөөн, эсхүл тухайн гадаргуу дээр байгаа хүн, өмч хөрөнгөд аюул учруулахаар бол; эсхүл
- (3) бусад улсын нутаг дэвсгэрийн агаарын зайд зөвшөөрөлгүй нэвтэрч болзошгүй бол.

#### **101.111. Шөнийн үйл ажиллагаа**

Аливаа этгээд нь, тухайн бөмбөлөг, түүнд бэхэлсэн хэрэгсэл болон дүүжилсэн төлбөрт ачаа нь тухайн үйл ажиллагааны үед салах эсэхээс үл хамааран, тус бүр нь дараах гэрлээр тоноглогдсоноос бусад тохиолдолд, хүнд чөлөөт бөмбөлгөөр 18 000 м-ээс (60 000ft) доош даралтын түвшинд шөнөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) 9км-ээс (5nm) багагүй зайд харагдахуйц;
- (2) минутад 40 - 100 үечлэлийн анивчих давтамжтай;
- (3) гэрэл бүр өөрийн тэжээлийн эх үүсгүүртэй.

#### **101.113. Сүүлэн антен**

Аливаа этгээд нь, дараах өнгөт дарцаг, эсхүл тууз уяж бэхэлснээс бусад тохиолдолд, аль ч хэсгээр нь таслахад 230 Ньютоноос их хүч шаарддаг сүүлэн антенаар тоногдсон чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхлэхгүй:

- (1) хоорондоо 15м-ээс ихгүй үечлэлтэй бэхлэгдсэн;
- (2) 1.8км-ээс (1nm) багагүй зайд харагдахуйц.

#### **101.115. Дүүжин хэрэгсэл**

Аливаа этгээд нь, хурц өнгөтэй задгай шүхрээс бусад дүүжин хэрэгсэл нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, 15м-ээс илүү урт дүүжин хэрэгслээр тоноглогдсон хүнд чөлөөт бөмбөлгөөр 18 000м-ээс (60 000ft) доош даралтын түвшинд, өдрөөр үйл ажиллагаа явуулахгүй:

- (1) алсаас харагдац сайтай эсрэг өнгөөр хосолсон өнгөтэй байх; эсхүл
- (2) 1.8км-ээс (1nm) багагүй зайд харагдахуйц өнгөт тууз, эсхүл дарцаг бэхэлсэн байх.

**101.117. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хөөргөхөөр төлөвлөсөн хугацаанаасаа 24-өөс доошгүй цагийн өмнө дараах мэдээллийг NOTAM-д хүргүүлээгүй бол, дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийг хөөргөхгүй:

- (1) тэдний нэр, утасны дугаар;
- (2) тухайн бөмбөлгийн таних тодорхойлолт, эсхүл төслийн кодын нэр;
- (3) тухайн бөмбөлгийн ангилал болон дараах мэдээллийг багтаасан тайлбар:
  - (i) тухайн бөмбөлгийн урт болон диаметр;
  - (ii) тухайн дүүжин хэрэгслийн урт;
  - (iii) тухайн төлбөрт ачааны жин;
  - (iv) тухайн сүүлэн антены урт;
- (4) хэрэв хамааралтай бол, SSR-ын код;
- (5) тухайн хөөргөх газрын байрлал;
- (6) тухайн тооцоот хөөргөх цаг, эсхүл олон дахин хөөргөх бол, эхлэх ба дуусах цаг;
- (7) тухайн хөөргөх бөмбөлгийн тоо, олон дахин хөөргөх бол, хөөргөлт хоорондын давтагдах хугацаа;
- (8) тухайн хөөрөх чиглэлийн баримжаа;
- (9) тухайн аяллын түвшинд хүрэх, эсхүл 18 000м-ийн (60 000ft) даралтын түвшинг огтлох тооцоот цагийн аль багыг;
- (10) тухайн төлөвлөсөн аяллын түвшин (даралтын түвшнээр);
- (11) тухайн нислэгийн төлөвлөсөн үргэлжлэх хугацаа;
- (12) газрын гадаргууд буух тооцоот цаг болон байрлал.

(b) Аливаа этгээд нь дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийг, цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл шаарддаг нарны, эсхүл сансрын идэвхжлийн нөлөөллийг судлах зорилгоор хөөргөх тохиолдолд, энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг бөмбөлөг хөөргөх тооцоот цагаас 30 минутаас доошгүй хугацааны өмнө мэдэгдэж болно.

(c) Энэ зүйлийн (a)-ийн дагуу өгсөн мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд, бөмбөлөг хөөргөх этгээд нь тухайн өөрчлөлтийг бөмбөлөг хөөргөхөөр төлөвлөсөн цагаас 6-аас доошгүй цагийн өмнө NOTAM-д мэдэгдэнэ.

**101.119. Хөөргөлтийн мэдээлэл**

Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь бөмбөлгийг хөөргөсний дараа хамгийн ойрын НХҮ-ний нэгжид дараах мэдээллийг нэн даруй мэдээлнэ:

- (1) тухайн бөмбөлгийн нислэгийн таних тодорхойлолт;

- (2) тухайн хөөргөлтийн газар;
- (3) тухайн хөөргөлтийн бодит цаг;
- (4) 18 000м-ийн (60 000ft) даралтын түвшинг огтлох тооцоот цаг, эсхүл хэрэв аяллын түвшин нь 18 000м-ийн (60 000ft) өндөрт, эсхүл түүнээс доош бол, хүрэх тооцоот цаг болон тооцоот байрлал;
- (5) 101.117(а)(7), эсхүл (8)-ын дагуу өгөгдсөн тухайн мэдээлэлд орсон аливаа өөрчлөлт.

#### **101.121. Цуцлалтын мэдээлэл**

Энэ дүрмийн 101.117-гийн дагуу хөөргөлтийн өмнөх мэдээлэл хүргүүлсэн аливаа этгээд нь хөөргөх үйл ажиллагааг цуцалсан бол, НХҮ-ний нэгжид тухайн цуцлалтын талаар нэн даруй мэдээлнэ.

#### **101.123. Бөмбөлгийн байршлыг илтгэх**

Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа явуулж байгаа аливаа этгээд нь:

- (1) тухайн НХҮ-ний нэгжээс өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд, хоёр цаг тутамд тухайн бөмбөлгийн чиглэлийг хянаж, түүний байршлыг бүртгэнэ;
- (2) тухайн НХҮ-ний нэгжээс хүссэн аливаа бөмбөлгийн байршлын мэдээллийг дамжуулна;
- (3) нислэгийн аливаа хоёр цагийн хугацаанд бөмбөлгийн байршлын мэдээлэл бүртгэгдээгүй тохиолдолд, ойролцоох НХҮ-ний нэгжид нэн даруй мэдээлнэ. Тухайн мэдээлэл нь:
  - (i) хамгийн сүүлд бүртгэгдсэн байршил;
  - (ii) баримжаат траекторт орсон аливаа өөрчлөлт агуулсан байна;
- (4) бөмбөлгийн замын хяналт эргэн тогтоогдвол, НХҮ-ний нэгжид нэн даруй мэдээлнэ.

#### **101.125. Өндөр алдалтын өмнөх байршлыг илтгэх**

Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах мэдээллийг, тухайн төлөвлөсөн өндөр алдалт эхлэхээс нэгээс доошгүй цагийн өмнө ойролцоох НХҮ-ний нэгжид өгнө:

- (1) тухайн байгаа газар зүйн байршил;
- (2) тухайн байгаа түвшин;
- (3) хамааралтай бол, 18 000м-ийн (60 000ft) даралтын түвшинг огтлох баримжаат цаг;
- (4) тухайн баримжаат өндөр алдалтын траектор;
- (5) тухайн газрын гадаргууд буух баримжаат цаг болон байрлал.

**101.127. Үйл ажиллагааны гүйцэтгэл**

Дунд, эсхүл хүнд чөлөөт бөмбөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа этгээд нь тухайн үйл ажиллагаа дуусахад ойролцоох НХУ-ний нэгжид мэдээлнэ.

**D Бүлэг - Пуужин****101.151. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг нь пуужингийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

**101.153 . Том загвар пуужин**

Аливаа этгээд нь Монголын Аэронавтикийн Холбооны Дүрмийн хүрээнээс гадуур том загвар пуужингаар үйл ажиллагаа эрхлэхгүй.

**101.155. Аэродром**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь аэродром дээр, эсхүл аэродромын хил хязгаараас 4км дотор пуужингаар үйл ажиллагаа явуулахгүй.

(b) Аливаа этгээд нь дараах тохиолдолд, аэродромын хил хязгаараас 4км дотор пуужингаар үйл ажиллагаа явуулж болно:

- (1) тухайн пуужин газрын түвшнээс дээш (AGL) 120м-ээс (400ft) дээш өндөрт нисдэггүй бол;
- (2) хяналтгүй аэродромд, тухайн үйл ажиллагаа нь аэродромын оператортой хийсэн гэрээний дагуу явагдаж байгаа бол;
- (3) хяналттай аэродромд, тухайн үйл ажиллагаа нь НХУ-аас авсан зөвшөөрлийн дагуу явагдаж байгаа бол;
- (4) аэродромын ашиглагдаж байгаа агаарын хөлгийн хөдөлгөөнт бүс дээр, эсхүл түүний дээгүүр үйл ажиллагаа явуулахгүй бол;
- (5) аливаа ашиглагдаж байгаа хөөрч буух зурвасын үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр үйл ажиллагаа явуулахгүй бол.

(c) Аливаа этгээд нь аэродромын хил хязгаараас 4 - 8км-ийн хоорондох зайд, газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт пуужингаар үйл ажиллагаа явуулахгүй.

**101.157. Цаг уурын хязгаарлалт**

(a) Тухайн этгээд нь дараах нөхцөлд пуужингаар аливаа түвшинд үйл ажиллагаа явуулахгүй:

- (1) үүлтэй, эсхүл тодорхой бус үзэгдэл 4-8 октантаас илүү хамарсан орчинд;
- (2) тухайн алсын барааны харагдац 8км-ээс бага орчинд;

(b) Аливаа этгээд нь пуужингаар үүл рүү үйл ажиллагаа явуулахгүй.



**101.159. Шөнийн үйл ажиллагаа**

Аливаа этгээд нь том загвар пуужингаас бусад пуужингаар шөнөөр үйл ажиллагаа явуулахгүй.

**101.161. Хөөргөлтийн өмнөх мэдээлэл**

Аливаа этгээд нь, хөөргөхөөс 24-өөс доошгүй цагийн өмнө NOTAM-д дараах мэдээллийг өгснөөс бусад тохиолдолд, том загвар пуужингаас бусад пуужинг хөөргөхгүй:

- (1) тэдний нэр, хаяг, утасны дугаар, эсхүл нэг арга хэмжээнд олон оролцогч байгаа бол, энэ зүйлийн (2), (3) болон (4)-т шаардсан хөөргөлтийн өгөгдөхүүний тооцоог багтаасан зохицуулах үүрэг бүхий тухайн хөөргөх арга хэмжээг удирдаж байгаа этгээдийн нэр, хаяг, утасны дугаар;
- (2) хөөргөхөөр төлөвлөсөн пуужингийн тоо;
- (3) пуужин бүрийн тооцоот хэмжээ болон тооцоот жин;
- (4) пуужин бүрийн хөөрч хүрэх хамгийн их тооцоот түвшин, эсхүл нислэгийн түвшин;
- (5) тухайн үйл ажиллагааны байрлал;
- (6) тухайн үйл ажиллагаа явуулах өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;
- (7) мэдээлэл авч байгаа этгээдийн хүссэн, аливаа бусад холбогдох мэдээлэл.

**Е Бүлэг - Зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай болон чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар****101.201. Хамрах хүрээ**

Энэ дүрмийн 102.21-ийг харгалзан, энэ Бүлэг нь дараах нисдэг төхөөрөмжид хамаарна:

- (1) зайнаас удирддаг агаарын хөлөг;
- (2) утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар;
- (3) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар.

**101.202. Зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага**

Энэ Бүлэгт заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллага гэж, зайнаас удирддаг агаарын хөлгийг зохион бүтээх, үйлдвэрлэх, эсхүл үйл ажиллагаа эрхлэх зохих мэдлэг, мэргэшилтэй, эсхүл агаарын зайн хуваарилалт, хязгаарлалтын талаар зохих мэдлэгтэй болон дараах тусгайлан заасан нэг, эсхүл хэд хэдэн ажиллагааг гүйцэтгэхийг Дарга зөвшөөрсөн этгээд, эсхүл байгууллагыг хэлнэ:

- (1) зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааны нисгэгчийн мэргэшил олгох; эсхүл

- (2) зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид зааварчилгаа өгөх этгээдийг томилох; эсхүл
- (3) NOTAM гаргахад зориулан, зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааны талаар нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлэх этгээдэд эрх олгох; эсхүл
- (4) 15кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлөг үйлдвэрлэх, эсхүл модификаци хийх эрх олгох; эсхүл
- (5) 15кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлөг үйлдвэрлэх ажиллагааг шалгах ба зөвшөөрөх; эсхүл
- (6) 15кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааг зөвшөөрөх.

### **101.203. Утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар**

Аливаа этгээдийг 30м-ээс урт нэг, эсхүл хэд хэдэн утсан удирдлагын систем бүхий агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

### **101.205. Аэродром**

(а) Аливаа этгээдийг зайнаас удирддаг агаарын хөлөг, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар дараах аэродром дээр, эсхүл түүнээс 4км дотор үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) хяналтгүй аэродромд, дараахаас бусад тохиолдолд:
  - (i) тухайн үйл ажиллагаа нь аэродромын оператортой хийсэн гэрээний дагуу хийгдэж байгаа бол;
  - (ii) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварын хувьд, тухайн агаарын хөлгийг ашиглагдаж байгаа хөөрч буух зурвасын салхины дагуу чиглэлд хөөргөх бол;
  - (iii) зайнаас удирддаг агаарын хөлгийн хувьд:
    - (А) тухайн агаарын хөлгийг нислэгт байх үед нисгэгч бүр дэргэдээ ажиглагчтай байгаа бол;
    - (В) тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь Даргаас, газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, тухайн агаарын хөлгөөр газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт үйл ажиллагаа явуулахгүй бол;
- (2) хяналттай аэродромд, тухайн үйл ажиллагаа нь холбогдох НХУ-ын нэгжээс авсан зөвшөөрлийн дагуу явагдаж байгаагаас бусад тохиолдолд;
- (3) аливаа аэродромд, дараахаас бусад тохиолдолд:
  - (i) тухайн этгээд нь:

- (A) зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас олгосон нисгэгчийн эрх эзэмшигч, эсхүл эрх бүхий нисгэгчийн шууд хяналтад байгаа бол; эсхүл
- (B) зайнаас удирддаг агаарын хөлгийн үйл ажиллагааны зааварчилгаа өгөхөөр, зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас томилогдсон этгээдийн шууд хяналтад байгаа бол; эсхүл
- (C) ИНД-61, эсхүл ИНД-149-ийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл гэрчилгээ эзэмшигч бол.
- (b) Аливаа этгээдийг зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:
- (1) аэродромын ашиглагдаж байгаа хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл
  - (2) ашиглагдаж байгаа хөөрч буух зурвасын үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр.
- (c) Энэ зүйлийн (a) нь дараах, халхлагдсан үйл ажиллагаанд хамаарахгүй:
- (1) тухайн аэродромын хил хязгаарын гадна;
  - (2) тухайн агаарын хөлгийн нислэгийг саатуулах боломжтой хаалтаар тухайн аэродромоос бодит байдлаар тусгаарлагдсан агаарын зайд.
- (d) Энэ зүйлийн (a)(3) нь чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загварт хамаарахгүй.

### **101.207. Агаарын зай**

- (a) Зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:
- (1) ИНД-71-ийн дагуу аюултай бүсэд үйл ажиллагаа явуулж байгаагаас бусад тохиолдолд, дараах агаарын зайд хийгдэх үйл ажиллагаанаас зайлсхийх:
    - (i) тухайн агаарын зайд үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тухайн агаарын хөлөгт олгоогүй этгээдийн дээгүүр;
    - (ii) тухайн өмчийг ашиглаж байгаа аливаа этгээд, эсхүл өмчийн эзэмшигчээс урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд, тухайн өмчийн дээгүүр;
  - (2) нислэг үйлдэж байгаа тухайн агаарын хөлгийн хүрээлэн буй агаарын орон зайд байгаа бусад агаарын хөлөгт тогтмол ажиглалт хийж байх;
  - (3) энэ зүйлийн (c)-гээс бусад тохиолдолд, газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш аливаа өндөрт агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулахгүй байх.
- (b) Хэрэв дараах нөхцөлд үйл ажиллагааг явуулж байгаа бол, энэ зүйлийн (a) нь тухайн этгээдийг аливаа зөвшөөрөл авахыг шаардахгүй:
- (1) зөвшөөрөгдсөн байгууллагын эрхийн хүрээнд;
  - (2) *хамааралгүй*

(с) Аэродромын хил хязгаараас 4км-ээс хол зайд, газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, тухайн үйл ажиллагаа G ангиллын агаарын зайд тогтмол явагдаж байгааг бататгах ёстой ба дараах үүрэгтэй:

- (1) ИНД-71-ийн дагуу тухайн зорилгоор тогтоосон аюултай бүс дотор үйл ажиллагаа явуулах; эсхүл
- (2) зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагаас эрх олгогдсон этгээд нь тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө дараах мэдээллийг NOTAM гаргах зорилгоор нисэхийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид мэдээлснийг бататгах:
  - (i) тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;
  - (ii) тухайн санал болгосон үйл ажиллагааны байрлал;
  - (iii) тухайн санал болгосон үйл ажиллагааг явуулах өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;
  - (iv) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд санал болгосон, газрын түвшнээс дээш максимум өндөр.

#### **101.209. Шууд харж удирдах үйл ажиллагаа**

(а) Энэ зүйл нь дараах төрлийн агаарын хөлөгт хамаарна:

- (1) зайнаас удирддаг агаарын хөлөг;
- (2) чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвар.

(b) Энэ зүйл хамаарах дараах нөхцөлд, аливаа этгээдийг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа явуулах, тухайн этгээдийн хараа халхлагдсан хүрээлэн буй агаарын зайн аливаа бүсэд; эсхүл
- (2) тухайн агаарын хөлгийг шууд харах тухайн этгээдийн харааг халхалсан цаг уурын нөхцөлд.

(с) Энэ зүйл хамаарах агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулж байгаа этгээд нь дараах шаардлагыг байнга мөрдөх үүрэгтэй:

- (1) тухайн агаарын хөлгийг шууд харах нөхцөлийг байнга хадгалах;
- (2) тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаа явагдаж байгаа хүрээлэн буй агаарын зайг харах боломжтой байх;
- (3) тухайн агаарын хөлгөөр, үүлний сууриас доогуур үйл ажиллагаа явуулах.

(d) Энэ зүйлийн зорилгоор, шууд харах гэдэг нь аливаа ажиглагч этгээд эгц шулуун шугамаар тод харахыг ойлгох бөгөөд, үүнд дараах төхөөрөмжийг ашиглаж болно:

- (1) тухайн хэрэглэгчийн хэвийн бус харааг засахад ашигладаг боловч хэвийн хараанаас илүү болгодоггүй, нүдний шил, контакт линз, эсхүл тэдгээртэй төстэй хэрэгсэл, гэхдээ электрон, механик, цахилгаан соронзон, оптик эсхүл электрон-оптик хэрэглэл хэрэглэхгүйгээр; эсхүл

- (2) дүрсийг дэлгэцээр харж удирдах систем болон сургалтад хамрагдсан, мэдлэг чадвартай ажиглагч дараах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байгаа бол:
- (i) тухайн агаарын хөлгийг шууд харж байх;
  - (ii) тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа явуулж байгаа хүрээлэн буй агаарын зайг харж хянах;
  - (iii) тухайн агаарын хөлгийг удирдаж байгаа этгээдтэй шууд холбоотой байх.

#### **101.211. Шөнийн үйл ажиллагаа**

Дараах үйл ажиллагаанаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг зайнаас удирддаг агаарын хөлөг, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар шөнөөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) дотор орчинд; эсхүл
- (2) халхлагдсан үйл ажиллагаа.

#### **101.213. Хөдөлгөөний давуу эрх**

(a) Зайнаас удирддаг агаарын хөлөг, эсхүл утсан удирдлагатай агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, тухайн агаарын хөлгийг удирдаж байгаа этгээд газар дээр болон нислэгт байгаа нисгэгчтэй агаарын хөлгүүдээс зайтай байж, зам тавьж өгч байгааг бататгах үүрэгтэй.

(b) Чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь агаарын хөлгийг хөөргөхөөс өмнө, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны үед газар дээр болон нислэгт байгаа нисгэгчтэй агаарын хөлгөөс зайтай, саадгүй байхыг бататгах үүрэгтэй.

#### **101.215. Агаарын хөлгийн жингийн хязгаар**

(a) Аливаа этгээдийг, нийт жин нь 25кг-аас дээш жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлөг, утсан удирдлагатай агаарын хөлгийн загвар, эсхүл чөлөөт нислэгийн агаарын хөлгийн загвараар үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

(b) Тухайн агаарын хөлөг болон түүнд хийсэн аливаа модификаци нь дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг, нийт жин нь 15кг-аас 25кг хүртэл жинтэй, зайнаас удирддаг агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) 101.202-т заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагын эрхийн хүрээнд үйлдвэрлэгдсэн, эсхүл үзлэг хийгдэж зөвшөөрөгдсөн байх;
- (2) 101.202-т заасан зөвшөөрөгдсөн этгээд, эсхүл байгууллагын эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байх.

## F Бүлэг - Жиро-глайдер, Парасэйл

### 101.251. Хамрах хүрээ

Энэ Бүлэг нь жиро-глайдер болон парасэйлийн үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно.

### 101.253. Аэродром

(а) Дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг жиро-глайдер, эсхүл парасэйлээр аэродром дээр, эсхүл аэродромын хил хязгаараас 4км дотор үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) тухайн жиро-глайдер, эсхүл парасэйл нь хяналтгүй аэродромд, дараах үйл ажиллагаа явуулж байгаа бол:
  - (i) тухайн аэродромын оператортой хийсэн гэрээний дагуу;
  - (ii) газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээшгүй өндөрт; эсхүл
- (2) тухайн жиро-глайдер, эсхүл парасэйл нь хяналттай аэродромд, тухайн аэродромын НХҮ-ний нэгжээс авсан зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа хийж байгаа бол.

(б) Аливаа этгээдийг жиро-глайдер, эсхүл парасэйлээр дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

- (1) аэродромын агаарын хөлгийн аливаа хөдөлгөөнт бүс дээр, эсхүл дээгүүр; эсхүл
- (2) аэродромын ашиглагдаж байгаа аливаа хөөрч буух зурвас, эсхүл хөөрч буух зурвасын үргэлжилсэн талбай дээр, эсхүл дээгүүр.

### 101.255. Агаарын зай

Газрын түвшнээс дээш 120м-ээс (400ft) дээш өндөрт жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг хангах үүрэгтэй:

- (1) тухайн жиро-глайдер, эсхүл парасэйл нь аэродромын аливаа хил хязгаараас 4км-ээс доошгүй хол зайд байгааг бататгах;
- (2) G ангиллын агаарын зайд үйл ажиллагаа эрхлэх;
- (3) тухайн үйл ажиллагаа эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө дараах мэдээллийг NOTAM-д хүргүүлэх:
  - (i) тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр, хаяг, утасны дугаар;
  - (ii) тухайн үйл ажиллагааны өдөр, цаг, үргэлжлэх хугацаа;
  - (iii) тухайн жиро-глайдер, эсхүл парасэйлийн товч тайлбар (хэмжээ, зонхилох өнгийг багтаасан);
  - (iv) тухайн жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа явуулах өндөр.

**101.257. Цаг уурын хязгаарлалт**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг мөрдөх үүрэгтэй:

- (1) үүлэн доогуур, 120м-ээс (400ft) илүү ойрхон үйл ажиллагаа эрхлэхгүй байх;
- (2) үйл ажиллагааны бүсийг, газрын алсын барааны харагдац 5км-ээс багагүй байх орчноор хязгаарлах.

(b) Энэ зүйлийн (а) нь жиро-глайдер, эсхүл парасэйлийн халхлагдсан үйл ажиллагаанд хамаарахгүй.

**101.259. Шөнийн үйл ажиллагаа**

Аливаа этгээдийг жиро-глайдер, эсхүл парасэйлээр шөнөөр үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

**101.261. Нислэгт тэнцэх чадвар**

Жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа явуулж байгаа этгээд, тэдгээр нь зориулалтандаа тохирч байгаа болон үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу нислэгт тэнцэх нөхцөлийг хангаж байгааг бататгах үүрэгтэй.

**101.263. Аюулгүй байдлын төхөөрөмж**

Жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аливаа этгээд нь жиро-глайдер, парасэйлээр тээвэрлэгдэж байгаа этгээд бүр дараах шаардлагыг хангасныг бататгах үүрэгтэй:

- (1) усан дээгүүр нислэг үйлдэх үед, эсхүл халин нисэх зай нь усан дээр байхаар бол, тохирсон хөвөх туслах хэрэгсэл өмссөн байх;
- (2) хамгаалалтын хатуу малгай өмссөн байх;
- (3) жиро-глайдер, эсхүл парасэйлд даруулга бүсээр бэхлэгдсэн байх;
- (4) парасэйлийн шүхрийн холбогч гогцооноос утас ороогч дамар хүртэл хэмжсэн, 180м-ээс (600ft) урт татлагаар чирэгдэж хөөрөх парасэйлийн үйл ажиллагааны хувьд, хэрэв онцгой нөхцөл үүсвэл, холбоо барих боломжит хэлбэрээр тоногдсон байх.

**101.265. Нислэгийн өмнөх зааварчилгаа**

Жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь, зорчигч бүр дараах мэдээллийг агуулсан нислэгийн өмнөх зааварчилгааг нислэг бүрийн өмнө авсныг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн нислэгийн мөн чанар;
- (2) тухайн нислэгийн хэвийн үйл ажиллагааны журам;
- (3) дараах шаардлагыг багтаасан онцгой нөхцөлийн журам:
  - (i) ослын төхөөрөмжийн байрлал болон түүнийг хэрэглэх;

- (ii) усанд буулт үйлдсэн, эсхүл чирэх холбоос тасарсан үед мөрдөх журам;
- (iii) хэрэв онцгой нөхцөл үүсвэл, жиро-глайдер, эсхүл парасэйлийн үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоо барих арга.

#### **101.267. Онцгой нөхцөлийн үед чирэх холбоосыг салгах**

Аливаа этгээдийг онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд, нислэгт жиро-глайдер, эсхүл парасэйлийн чирэх холбоосыг салгахыг хориглоно.

#### **101.269. Үйл ажиллагааны журам**

Жиро-глайдер, эсхүл парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь тухайн үйлдвэрлэгчийн зөвлөсөн үйл ажиллагааны журам болон хязгаарлалтыг мөрдөх үүрэгтэй.

#### **101.271. Салхины хурд**

Парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) парасэйлээр үйл ажиллагаа явуулж байхдаа, тухайн байрлалын салхины хурдыг нарийн тогтоох болон хянах төхөөрөмж, эсхүл аргыг ашиглах;
- (2) салхины тогтвортой хурд нь 10м/с-ээс (20knot) их нөхцөлд парасэйлээр үйл ажиллагаа явуулахгүй байх.

#### **101.273. Зорчигчийн насны хязгаарлалт**

Парасэйлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд дараах үйл ажиллагааг хориглоно:

- (1) 8-11 настай бие даасан зорчигчийг (solo passenger) тээвэрлэх үед, парасэйл шүхрийн холбогч гогцооноос утас ороогч дамар хүртэл хэмжсэн, 90м-ээс (300ft) илүү уртасгасан чирэх татлагаар парасэйлийн үйл ажиллагаа явуулахыг;
- (2) хэрэв онцгой нөхцөл үүсвэл, тухайн бага насны зорчигчид туслалцаа үзүүлэх чадвартай 18-аас доошгүй настай өөр зорчигч дагалдахаас бусад тохиолдолд, 8-аас доош насны зорчигчийг парасэйлээр тээвэрлэх үйл ажиллагаа явуулахыг.

--oOo--